

“Силикат” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн
ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ.

2015 оны 04 сарын 30

Дархан-Уул аймаг.

“Силикат” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн хурал тус компанийн хурлын зааланд 2015 оны 04 сарын 30-ны өдөр 15.00 цагт хуралдав.

Хурлын ирц:

Нэрс	Эзэмшиж буй хувьцааны тоо	Хувь
1. Ц.Сэргэлэн /хурлын дарга/	451,704 ш	0,98%
2. Ц.Содбилэг	7,511,526 ш	16,21%
3. Д.Энхболд	3,845,502 ш	8,3%
4. В.Мөнхтуяа	3,613,455 ш	7,8%
5. С.Асылхан /итгэмжлэлээр/	6,539,619 ш	14,12%
6. Р.Энхбат /итгэмжлэлээр/	5,699,223 ш	12,3%
7. Н.Цогцлон	2,258,520 ш	4,87%
8. Силикат ХК	15,832,926 ш	34,17%
9.		
10.		
11. Саналын хуудсаар		
Нийт	45,945,228 ш	98,74%

Хувьцаа эзэмшигчдийн хуралд нийт хувьцааны 98,74 % буюу 45,752,475 ширхэг хувьцаа эзэмшиж буй 7 хувьцаа эзэмшигчдийн бүрэлдхүүнтэй хуралдлаа.

Хуралд С.Асылхан нь хувьцаа эзэмшигч С.Золбоотөгсийн итгэмжлэлээр, Р.Энхбат нь хувьцаа эзэмшигч С.Оджаргалын итгэмжлэлээр оролцов.

Хурлын дарга Ц.Сэргэлэн: Өнөөдрийн хурлаар 3 асуудлыг хэлэлцнэ

1. Компанийн 2014 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлт.
2. Хувьцаат компанийн хэлбэрийг Хязгаарлагдмал хариуцлагатай компани болгон өөрчлөн байгуулах тухай.
3. Компанийн нэгж хувьцааны нэрлэсэн үнийг 79.40 төгрөгөөр шинэчлэн тогтоох тухай. Хэлэлцэх асуудлаа батлах уу? батлана гэсэн нь гараа өргөнө үү?

Хуралд оролцогчид 100 %-ийн саналаар баталлаа.

Хурлын дарга хурлын дэгийг танилцуулав.

Асуултаа асуугаад саналаа хэлээд зэрэг явуулах уу эсвэл асуултаа асуугаад санал нь тусдаа байх уу? Миний бодлоор асуултаа асуугаад саналаа хэлээд явчихвал яаж байна? /хүмүүс зөвшөөрч асуултаа асуугаад саналаа хэлээд зэрэг ярилцахаар болов/. Өнөөдрийн хурлаа 15 цаг минутад эхэлж өнөөдөртөө багтаагаад дуусгах уу? /Хүмүүс 100% зөвшөөрч хурлаа эхлэв/.

Содбилэг: Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд:

- 2014 онд үйлдвэрлэлийн үйл ажиллагаа хэрхэн явагдаж ирсэн болон үйлдвэрлэлийн үйл ажиллагаа, бүтээгдэхүүний борлуулалт санхүүгийн тайлангийн талаар товч илтгэл
- Хувьцаат компанийн хэлбэрийг Хязгаарлагдмал хариуцлагатай компани болгон өөрчлөн байгуулах төслийн тухай
- Компанийн нэгж хувьцааны нэрлэсэн үнийг 79.40 төгрөгөөр тогтоох тухай зэрэг асуудлаар тус тус илтгэл тавив.

Нэг: 2014 оны үйлдвэрлэлийн үйл ажиллагаа, бүтээгдэхүүний борлуулалт санхүүгийн тайлангийн талаар.

2014 онд силикат компани хөдөлмөрийн сахилга, мэргэжлийн ур чадвар, урамшуулал, хариуцлагын механизмыг ажлын байр бүрт хэрэгжүүлснээр үйлдвэрлэлийн өртөг, зардлыг хамгийн бага түвшинд хүргэж бүтээгдэхүүний чанар нь стандартын шаардлагад бүрэн нийцсэн, гологдол, хаягдалгүй үйлдвэрлэл явуулах зорилго дэвшүүлэн ажиллаа.

Тус компани 2010-2011 онд жилдээ 26000 метр куб хөнгөн бетон үйлдвэрлэж 3,6 тэрбум төгрөгийн борлуулалт хийдэг байсан боловч сүүлийн жилүүдэд бүтээгдэхүүний борлуулалт жил тутамд буурч өнгөрсөн жилд 900 сая төгрөгийн борлуулалт хийсэн нь орлого өмнөх жилүүдээс 4 дахин, 2011 оны хэрэгжүүлэхээр тусгасан төсөлийн төсөвийн орлогоос 7.8 тэрбум төгрөгөөс 10 дахин буурсан санхүүгийн маш муу үзүүлэлт болж байна. Бүтээгдэхүүний борлуулалт олон дахин буурсан нь дараах хэд хэдэн үндсэн шалтгаантай гэж дүгнэж байна.

1. Засгийн газраас 2013-2014 онуудад Чингис бондын хөрөнгөөр “Үнэ тогтворжуулах хөтөлбөр” хэрэгжүүлж БНХАУ-аас их хэмжээний цемент, хөнгөн бетон, арматур оруулж ирсэн. Ингэснээр дотоодын барилгын материалын үйлдвэрүүдийн борлуулалт буурсан. Энэ нь манай үйлдвэрийн борлуулалтанд нөлөөлж манай үйлдвэр хэд хэдэн удаа сул зогссон.
2. Силикат компани ЕСБХБанканд 727 сая төгрөгийн өртөй, энэ нь чанаргүй зээлийн муу гэх ангилалд ангилагдсан, шүүхийн шийдвэрээр бүтүүмжлэгдсэн байсан. Гэтэл СЗХороо нь ...ЕСБХБанк-Силикат компанийн хооронд байгуулагдсан “өр төлбөр барагдуулах 24 тоот гэрээ, гэрээгээр баталгаажуулсан 727 сая төгрөгийн өрийг мэдсээр байж Хорооны 241-р тогтоолын 9.2-д: бусдад төлөх өрийг 1.4тэрбум төгрөгөөр төлөхийг ҮЦГТХТ/Д.Гандулам/-д үүрэг болгосон нь маргаан үүсгэж шүүхэд хандахад хүргэж, 3 жилийн хугацаанд 6 шатны шүүхээр явсан.
3. Шүүхээр маргасан 2011-2014 оны энэ 3жилийн хугацаанд валютын ханш, тоног төхөөрөмжийн үнэ, тээвэр, гааль, бензин тос масло, уур, дулаан, цахилгаан г.м. бүх юмны үнэ 2-3 дахин нэмэгдэж төсөл хэрэгжих боломжгүй болсон. Төсөл хэрэгжсэнээр жилд 7.8 тэрбум төгрөгийн орлого олно гэж тооцоод нэгж хувьцааны үнийг 225 төгрөгөөр тогтоосон, өнөөдрийн 900 сая төгрөгийн борлуулалтыг орлогын хандлагаар тооцож үзвэл нэгж хувьцааны үнэ 25.65 болж байна.
4. 2010-2014 оны хооронд улсын хэмжээнд 38 хөнгөн бетоны үйлдвэр ашиглалтанд орж, өнөөдөр үйлдвэрлэл явуулж байна. Эдгээр үйлдвэрийн 95% нь Улаанбаатар хотод, үлдэх хэсэг нь орон нутагт үйлдвэрлэл явуулж, үнээр өрсөлдөх болсон нь манай борлуулалтыг бууруулж байна. Эдгээр үйлдвэрүүдийн нэрсийг баримтаар хавсаргаж байна

5. Өнөөдөр Монгол улс эдийн засгийн хямралд өртөж иргэдийн худалдан авах чадвар буурсан, барилгын салбар зогсонги байдалд орсон нь манай борлуулалтанд сөрөгөөр нөлөөлж байна.

2014 оны 3 сарын сүүлчээс манай компани засварын ажлыг эхлүүлэн 5-р сараас үйлдвэрлэл явагдаж эхэлсэн боловч 07 сарын эхэнд бүтээгдэхүүний захиалга бага хэмжээгээр ирсэн. Энэ хугацаанд бэлэн бүтээгдэхүүнээр талбайн дүүргэлт хийгдсэн боловч бүтээгдэхүүний борлуулалт бэлэн болон бэлэн бус хэлбэрээр хийгдэх байдал хангалтгүй болж, иргэд, аж ахуйн нэгж ихэвчлэн бараа солилцооны хэлбэрээр худалдан авалт хийх хүсэлтэй болсон нь компанийн санхүүд сөргөөр нөлөөлөх нэг хүчин зүйл болсон. Улс орны эдийн засгийн хүндрэлээс шалтгаалан 2014 оны 08 сараас эхлэн бүтээгдэхүүн борлуулалт эрс муудсан нь бүтээгдэхүүн борлуулалтанд сөргөөр нөлөөлж үүнээс улбаалан хэд хэдэн удаа үйлдвэрлэлийг сул зогсолтонд оруулах байдалд хүргэлээ. 2014 оны эцэст борлуулалтгүй болсны улмаас үйлдвэрлэлийг зогсоосон. Гэвч өнгөрөгч онд хөрөнгийн зах зээлд нэмж гаргасан хувьцаагаа эргүүлэн худалдан авч Ц.Содбилэг нарын нэгдмэл сонирхолтой этгээдийн өмчлөл дэх хувьцаа компанийн нийт хувьцааны 99,6 хувь боллоо. Үүнийг тухайн жилд хийсэн их том ажил гэж үзэж байна. Түүнчлэн бусдад төлөх өр төлбөр болох 500 орчим сая төгрөгийн төлбөрийг барагдуулж чадсаныг дурьдахад таатай байна.

Хоёр. Хувьцаат компанийн хэлбэрийг Хязгаарлагдмал хариуцлагатай компани болгон өөрчлөн байгуулах төслийн тухай.

Хувьцаа эзэмшигчдийн хурлын материалд компанийн хэлбэрийг өөрчлөх төсөл болон хязгаарлагдмал хариуцлагатай компанийн дүрмийн төслийг оруулсан. Уг төсөлүүдтэй та бүхэн тодорхой танилцсан гэж бодож байна. Хувьцаат компанийг хязгаарлагдмал хариуцлагатай компани болгон өөрчлөх тухай асуудал нь өнөөдрийн энэ ээлжит хурлаар шийдвэрлэх гол асуудал гэж үзэж байна. Хэлэлцэх асуудлаар хувьцаа эзэмшигчдийн саналаар компанийн хэлбэрийг өөрчлөх асуудлыг шийдвэрлэх бөгөөд компанийн хэлбэрийг өөрчлөх шалтгааны талаар хурлын материалд тодорхой орсон учраас энэ тухай дахин давтмааргүй байна. Хэлбэр өөрчлөх асуудлыг хувьцаа эзэмшигчид олонхоор дэмжсэн дүн гарсан тохиолдолд Силикат ХК-ийн саналын эрхтэй хувьцаа эзэмшигчид дахин хуралдаж “Силикат”ХХК-ийг байгуулах, компанийн дүрмийг батлах, ерөнхий захиралыг томилох зэрэг асуудлыг хамтад нь авч хэлэлцэн шийдвэрлэх болно.

Хязгаарлагдмал хариуцлагатай компани нь Төлөөлөн удирдах зөвлөлгүй дээд байгууллага нь хувьцаа эзэмшигчид байх бөгөөд хувьцаа эзэмшигчдийн хурлаас ХХК-ийн ерөнхий захиаралыг томилоно. Компанитай холбоотой бусад эрх, үүрэг, үйл ажиллагааны чиглэл хүлээх хариуцлага зэрэг нь хувьцаат компанийн дүрэмд нийтлэг орсон агуулгатай ижил юм.

Компанийн хэлбэрийг өөрчлөх талаарх техникийн бусад ажиллагааг холбогдох хууль тогтоомжийн дагуу томилогдсон ажлын хэсэг хуулийн хугацаанд хэрэгжүүлэн ажиллана.

Гурав: Компанийн нэгж хувьцааны нэрлэсэн үнийг 79.4 төгрөгөөр

тогтоох тухай.

“Шохойн төсөл” хэрэгжсэнээр жилд 7.7 тэрбум төгрөгийн орлого олно гэж тооцон нэгж хувьцааны анхны үнийг 225 төгрөгөөр тогтоосон. Гэвч өнгөрсөн хугацаанд жилд 900 сая төгрөгийн борлуулалт хийх болсон бөгөөд компанийн нийт хувьцааны үнийг орлогын

11-УУЛ АЯМАГ

УЛСЫН
ХК

144 2050403

11-УУЛ АЯМАГ

үнэлгээний аргаар тооцон үзэхэд нэгж хувьцааны зах зээлийн өнөөгийн бодит үнэ 26.55 төгрөг болж байна.

Үл хөдлөх хөрөнгийн үнэлгээ, бизнес зөвлөх үйлчилгээний “Итгэлт-Эстимейт”ХХК 2015 оны 04 сард манай компанийн хөрөнгийн үнэлгээг хийгээд тус компанийн нэгж хувьцааны үнийг хөрөнгийн үнэлгээний аргаар тооцоод, “Силикат”ХК-ийн нэгж хувьцааны зах зээлийн бодит үнэ 79,40 төгрөг болохыг тогтоосон. Иймд 2015 оны 04 сарын 30-ны өдөр хуралдах “Силикат”ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд тус компанийн нэгж хувьцааны нэрлэсэн үнийг 79.40 төгрөгөөр тогтоохоор хэлэлцүүлэхээр санал оруулж байна.

Компанийн тухай хуулийн 54-д заасны дагуу хувьцаа худалдан авахыг шаардах эрхийг хангах ажлыг хэрэгжүүлнэ. Компанийн хэлбэрийг өөрчлөхөд холбогдолтой бүх баримт бичгийг хувьцаа эзэмшигчдийн хурлын материалд хавсарган тараасан болно.

С.Асылхан: Шинээр байгуулах хязгаарлагдмал хариуцлагатай компани нь ТУЗ-тэй байх уу? ТУЗ байвал хэдэн хүний бүрэлдхүүнтэй байх вэ?

Ц.Содбилэг: ХХК-ийн дүрэмд зааснаар ТУЗөвлөлгүй ажиллана. Компанийн эрх барих дээд байгууллага нь хувьцаа эзэмшигчид байна.

Д.Энхболд: ХХК-ийн дүрмийн төсөлтэй танилцлаа. Төсөлд Ерөнхий захирлыг хувьцаа эзэмшигчдийн хурлаас томилно гэж заажээ. Энэ заалтын дагуу ерөнхий захирлыг томилохдоо ХХК-ийн хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцож байгаа Хувьцаа эзэмшигчдийн олонхийн саналыг авсан хүн томилогдох уу.

Ц.Сэргэлэн: ХХК-ийн дүрмийн төсөлд заасны дагуу хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцогчдын олонхийн саналыг авсан нэр дэвшигчийг тухайн хурлаас томилно.

В.Мөнхтуяа: Хувьцаат компанийг ХХК болгон хэлбэрийг өөрчилжөөр олонхи нь саналаа өгчээ. Энэ тохиолдолд Силикат ХХК-г хэзээ хуулийн этгээд болсон гэж тооцох вэ?

Ц.Содбилэг: Энэ тохиолдолд өнөөдрийн хурлаас гарсан шийдвэрийг Санхүүгийн зохицуулах хороонд хүргүүлж, Хороо Силикат ХК-ийг Силикат ХХК болгох тухай тогтоол гаргасны дараа өөрчлөн байгуулагдаж байгаа аж ахуйн нэгжийг УБЕГ-ын хуулийн этгээдийн бүртгэлийн газарт бүртгүүлэхээр өргөдөл гаргаж тухайн газар бүртгэж авсанаар Силикат ХХК байгуулагдсан гэж тооцно.

Р.Энхбат: ХХК-ийн ерөнхий захирлын албан тушаалд өөр газраас буюу сонирхсон этгээд нэрээ дэвшүүлж болох уу.

Ц.Содбилэг: Уг албан тушаалд хэн ч нэрээ дэвшүүлж болно. Гэхдээ компаниас энэ тал дээр манай компанийн хувьцаа эзэмшигчдийн дотроос ерөнхий захирлыг томилох нь зүйтэй гэсэн бодлого барьж байгаа.

B

Д.Энхболд: Силикат ХК-ийн нэгж хувьцааны нэрлэсэн үнийг 79,40 төгрөг болгох төслийн санал оруулжээ. Энэ нэгж хувьцааны үнэ хэр бодитой вэ?

Ц.Сэргэлэн: Нэгж хувьцааны нэрлэсэн үнийг тогтоох 3 үндсэн аргачлал байгаа.

- Компаний орлогын чиг хандлагаар нэгж хувьцааны үнийг өнөөгийн зах зээлийн бодит ханшаар үнэлэхэд манай компанийн нэгж хувьцааны нэрлэсэн үнэ нь 26,55 төгрөг болсон.
- Хөрөнгө үнэлгээний Итгэлт-Эстимэйт ХХК-ийн хийсэн бизнес үнэлгээгээр Силикат ХК-ийн нэгж хувьцааны нэрлэсэн үнийг 79,40 төгрөг гэж тогтоосон. Бид энэхүү 79,40 төгрөгийг зах зээлийн үнэ ханшид тохирсон үнэ гэж үзээд өнөөдрийн хурлаар хэлэлцүүлж байна.

Ц.Сэргэлэн: Хуралд оролцогчдоос өөр асуулт тайлбар авах хүн байна уу? Байвал асуулт тавьж тайлбар авч болно. Хуралд оролцогчдоос нэмж асуулт болон тайлбар авах санал гарсангүй.

Ц.Сэргэлэн: Асуулт дууссан бол хурлаар хэлэлцэж буй хувьцаат компанийг хязгаарлагдмал хариуцлагатай компани болгон хэлбэрийг өөрчлөх, нэгж хувьцааны нэрлэсэн үнийг 79,40 төгрөгөөр тогтоох асуудлаар саналаа шууд хураая гэснээр хуралдаанд оролцогчид ХК-ийг ХХК болгож хэлбэрийг өөрчлөх болон нэгж хувьцааны нэрлэсэн үнийг 79,40 төгрөг болгох саналыг 100 %-ийн саналаар зөвшөөрч батлав.

Тооллогын комиссын дарга Д.Уранчимэг: Тооллогын комиссын дүн гарлаа.

2015. 04. 30.

Дархан-Уул аймаг.

Силикат ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн хуралд нийт хувьцааны 98,74% буюу 45,752,475 ширхэг хувьцаа эзэмшиж буй 7 хувьцаа эзэмшигчдийн бүрэлдхүүнтэй хуралдаж санал хураалтанд дараах шийдвэр гарав.

Тооллогод нийт хувьцаа эзэмшигчдийн 98,74% буюу 45,752,475 ширхэг хувьцаа эзэмшиж буй 7 хувьцаа эзэмшигчдийн саналыг саналын хуудсаар авсан ба 100% хүчинтэй байлаа.

Санал хураасан: нэгдүгээр асуудлаар хуралд оролцогчид 100%-ийн саналаар зөвшөөрсөн.

Татгалзсан 0%, түтгэлзсэн 0% байлаа.

Хоёр дугаар асуудлаар хуралд оролцогчид 100%-ийн саналаар зөвшөөрсөн.

Татгалзсан 0%, түтгэлзсэн 0% байлаа.

Сэргэлэн. Сая тооллогын комиссын дүнтэй танилцлаа. Одоо хурлаас гарах тогтоолоо танилцуулья.

Силикат ХК-ийн ээлжит хурлын тогтоол.

2015.04.30.

Дугаар № 01/01.

Дархан-Уул аймаг.

Компанийн үнэт цаасны бүртгэлд өөрчлөлт оруулан, нэмж гаргасан хувьцааг бүртгэлээс хасах тухай Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.2.12, “Силикат” ХК-ийн Хувь нийлүүлэгчдийн ээлжит хурлын тооллогын комиссын дүнг үндэслэн

ТОГТООХ НЬ:

1. “Силикат”ХК-ийг “Силикат”ХХК болгон өөрчлөн байгуулахаар тогтоосугай.
2. Компанийн нэгж хувьцааны нэрлэсэн үнийг 79.40 төгрөгөөр тогтоосугай.
3. “Силикат” ХК-ийг “Силикат” ХХК болгон өөрчлөн, компанийг нийт 45,945,228 ширхэг хувьцаатай байхаар тус тус тогтоон компанийн хэлбэрийг өөрчлөх ажлыг хуулийн хугацаанд сайн зохион байгуулан ажиллахыг ажлын комисс /Н.Цогцлон/-д үүрэг болгосугайг гэсэн тогтоол гарч байна.

Тооллогын комиссын тогтоолыг хавсаргав.

Хурал 17 цаг 29 минутад дуусав.

Тэмдэглэл хөтөлсөн:



/Р.Энхгэрэл/